



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 0/287

Хэрлэн сум

Өндөрхаан хайрхныг тахиx
ажлын хэсэг байгуулж, хөрөнгө
зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Билгийн тооллын зуны тэргүүн сарын шинийн гуравны өдрийг тохиолдуулан Өндөрхаан хайрхныг тахиx арга хэмжээнд зориулж, 3,555,900 (гурван сая таван зуун тавин таван мянга есөн зуу) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.


2.Өндөрхаан хайрхныг тахиx ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, хөрөнгө зарцуулалтын тооцоог 2 дугаар хавсралтаар баталсугай.

3.Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгож захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын...-ны өдрийн
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

- | | | |
|-----------------------|----------------|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Ж.Гантулга | Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга |
| Нарийн биичиг: | Т.Баяржаргал | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн дарга |
| Гишүүд: | Н.Хүрэлээ | Цэргийн штабын дарга |
| | Б.Дарханбаатар | Хууль, эрх зүйн хэлтсийн дарга |
| | Л.Наранбат | Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга |
| | Ц.Батцоож | Мөрөн сум Засаг дарга |
| | Д.Дамбажамц | Гүндгаравлин хийдийн хамба лам (зөвшилцсөнөөр) |
| | Я.Ганбат | Шадавдаржаалин хийдийн хамба лам (зөвшилцсөнөөр) |



Аймгийн Засаг даргын 2023 оны
 дугаар сарын 05-ны өдрийн
 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

Өндөрхаан хайрханы тахилгад шаардлагатай
 материалын үнийн жагсаалт

д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Хэвийн боов	ш	25	4500	112500
2	Еэвэн	ш	1	19000	19000
3	Боргоцой	ш	1	2500	2500
4	Ааруул	кг	12	8400	100800
5	Нойтон салфетки	ш	3	3650	10950
6	Цагаан будаа	кг	25	3400	85000
7	Сүү	л	10	5100	51000
8	Хуурай цай	ш	3	4500	13500
9	Тахилын боов	ш	300	2800	840000
10	Ламын зэд	ш	20	50000	1000000
11	Арц	ш	10	2500	25000
12	Хуж	ш	10	3250	32500
13	Хадаг/цэнхэр/	ш	5	3900	19500
14	масло	кг	5	9900	49500
15	Элсэн чихэр	кг	5	3700	18500
16	Сонгино	кг	4	2900	11600
17	Үзэм	кг	5	11000	55000
18	Арвай будаа	ш	1	5000	5000
19	Хийморийн дарцаг	ш	3	4000	12000
20	Аяганы арчуур	ш	3	6000	18000
21	Нэг удаагийн уут	ш	350	15	5250
22	Шүдэнз том	ш	3	650	1950
23	Газ	ш	1	3500	3500
24	Шар тос	ш	1	9600	9600
25	Нэг удаагийн халбага	ш	300	100	30000
26	Нэг удаагийн аяга	ш	300	80	24000
27	Салфетки хуурай	ш	3	3600	10800
28	Ургамалын тос	ш	5	11700	58500
29	Давс	ш	1	2000	2000
30	Шар будаа	кг	1	3250	3250
31	Гурил	кг	10	2300	23000
32	Нэг удаагийн таваг	ш	50	140	7000
33	Ууц	ш	33	16000	528000
34	АЗД-н айлдвар	ш	1	25000	25000
35	Дотортой шуудай	ш	1	2500	2500
36	Хуурай түлээ	ш	10000	10300	103000
	Дүн				3226500

Өндөрхаан хайрханы тахилгын ёслолд зарцуулагдах
 шатахууны үнийн тооцоо

д/д	Автамашины төрөл	Шатахууны төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Ланд крузер 00-01 хэа	ДТ	л	20	3870	77400
2	Ланд крузер 00-03 хэа	АИ 92		20	2520	50400
3	Ланд крузер	АИ 92		20	2520	50400
4	Пургон	АИ 92		20	2520	50400
5	Пургон	АИ 92		20	2520	50400
6	Пургон	АИ 92		20	2520	50400
	дүн					329400
						Нийт дүн
						3555900